



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 5/21

Улаанбаатар хот

Үндэсний стандарт шинээр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3.1, 11.3.2, 11.3.3, 11.3.4, 25.3.2 дахь заалт, Нийтлэг үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хурлын дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинээр боловсруулсан "MNS 6841 : 2020, Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага" стандартыг улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар шинээр баталсугай.
2. Шинээр баталсан стандартыг мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Стандартыг сурталчлах ажлыг зохион байгуулахыг "Буяны зан үйлийн холбоо" ТББ-д зөвлөмжилсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




020015586



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ.
Оршуулгад хамаарах үйлчилгээ.
Ерөнхий шаардлага.

MNS 6841 : 2020



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Улаанбаатар хот
2020 он

Оршил

Оршуулгын зан үйл бол тухайн улс, үндэстний соёлын нэгээхэн хэсэг байдаг. Манай өвөг дээдэс оршуулгын ёсыг чанд баримталж, соёлын томоохон зан үйл болгодог төдийгүй хорвоогоос одсон нэгнийгээ хүндэтгэлтэйгээр үддэг байжээ. Хүмүүн бид урт насалж удаан жаргах ганцхан эцсийн нэгдмэл хүсэлтэй. Үүний тулд бид, эрүүл саруул орчинд амгалан тайван амьдрах учиртай.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг эдэлнэ: “Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцвэр алдахаас хамгаалуулах эрхтэй.” хэмээн зарлан тунхагласан.

Өнөөдөр дэлхий дахинаа байгаль орчноо хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангаж цар тахлаас сэргийлэх зэрэг асуудлууд хурцаар тавигдаж байна.

Энэхүү асуудлын хүрээнд талийгаачаа нутаглуулах нь зөвхөн “талийгаач”-ийн болоод ар гэрийн хувийн асуудал бус холбогдох салбар бүрт шууд болон дам хамаарах өөрийн гэсэн онцлогтой, төрийн зохицуулалт шаардсан асуудал болон урган гарч байна.

Дэлхий даяар оршуулгын үйл ажиллагаа түүнтэй хамаарах төрөл бүрийн зохицуулалт шаардагдахаар болж байна. Энэ нь, талийгаач, тэдний гэр бүлд хүндэтгэлтэй хандах, хүрээлэн буй орчин, халдвар тархалтаас сэргийлэх зэрэг асуудлын хүрээнд шийдвэрлэх шаардлагууд гарч болох юм.

Дээрх асуудлыг шийдвэрлэхэд, стандартаар тогтоосон шаардлага, хэм хэмжээ нь чухал тул “Буяны зан үйлийн холбоо” ТББ-ын санаачилгаар Монгол улсын хууль эрхийн актад нийцүүлэн Олон улсын оршуулгын холбооноос гаргасан зөвлөмж, Европын холбооны улс ба ОХУ-ын стандартыг ижилтгэх хэмжээнд үндэслэл болгон стандартыг боловсруулсан.

“Буяны зан үйлийн холбоо” ТББ нь Олон улсын оршуулгын холбоо /ICCFА/-д 2005 онд, Ази-Австралийн оршуулгын холбоо /ACCA/-д 2008 онд, Үндэсний оршуулгын захирлуудын холбоо /NFDA/-д 2009 онд, Европын оршуулгын холбоо /FIAT-IFTA/-д 2010 онд тус тус нэгдэн орсон. Гишүүн байгууллагын хувьд тэдгээрээс туршлага судлах, мэргэжлийн зөвлөгөө авч хамтарч ажилладаг билээ. Тус олон улсын холбоодын шугамаар жил бүр зохиогддог их хуралд төлөөлөгчдөө тогтмол оролцуулан туршлага судлуулах, АНУ-ын Олон улсын оршуулгын холбооны их сургууль, БНХАУ-ын Шанхай хотод урт, богино хугацааны мэргэжлийн сургалтад хамруулан дадлагажуулах арга хэмжээг тогтмолжуулсны үр дүнд мэргэжлийн өндөр ур чадвартай, техник технологийн мэдлэг туршлагатай, ёс суртахууны болон сэтгэл зүйн, биеийн хүчний хувьд бэлтгэгдсэн ажилтнууд, үйлчилгээний ажилчдаас бүрдсэн чадварлаг боловсон хүчнийг шинээр бий болгон, хүний нөөцийг бүрдүүлж байна. Мөн жил бүр салбарын танин мэдэхүйн, орчин үеийн техник технологийн талаарх сургалт, семинар, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулдаг.

Буяны зан үйлийн холбоо нь Монгол улсад оршуулгын үйлчилгээ эрхэлдэг салбарын 14-н байгууллагыг тус холбоонд гишүүнчлэлээр нэгтгэсэн, цаашид хамтдаа бүс нутаг, олон улсын хамтын ажиллагаанд цар хүрээгээ өргөжүүлэн тэлэх зорилготой.

Оршуулгын үйл ажиллагаа, үйлчилгээ нь хүн ёсны зарчим шаарддаг, иргэн, аж ахуйн нэгж, төрийн ба төрийн бус байгууллага хэн бүхний хамтын үйл ажиллагаа, дэмжлэгт түшиглэсэн орчлон ертөнцөд ирсэн хүнийг үдэн гаргах хүндэтгэл үзүүлж байгаа эрхэм чухал үйл хэрэг юм. Энэ нь улс эх орны соёл, үндэстний оршин тогтнох эв санааг нэгтгэн зангидах эргэх буцах холбоо юм.

Шинээр гарч байгаа энэхүү стандарт нь нийгмийн тусын тулд хийж байгаа бидний үйл хэргийн нэгээхэн хэсэг бөгөөд Монгол улсын ирээдүйн хөгжил дэвшилд зохих хувь нэмрээ оруулан, хөгжил дэвшилд хөтлөх болтугай.

АГУУЛГА**Өмнөх үг**

ii

Оршил iv

1 Хамрах хүрээ 1

2 Норматив эшлэл 1

3 Нэр, томъёо тодорхойлолтууд..... 2

3.1 Талийгаа, түүнд хамаарах ойлголт 2

3.2 Оршуулгын үйлчилгээнд хамаарах ойлголт 4

3.3 Баримт бичигт хамаарах ойлголт 6

3.4 Оршуулгын газарт хамаарах ойлголт 7

3.5 Оршуулгын байгууламжид хамаарах ойлголт 8

4 Ерөнхий шаардлага 8

4.1 Оршуулгад хамаарах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага 8

4.2 Оршуулгад хамаарах үйлчилгээний төрлүүдэд тавих шаардлага 10

4.3 Оршуулгын газарт тавих шаардлага 16

4.4 Оршуулгын байгууламжид тавих шаардлага..... 16

4.5 Байгууллагад тавих шаардлага..... 17

А хавсралт 19

А хавсралт (үргэлжлэл)..... 20

В хавсралт 21

Ном зүй 22

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг Монгол улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1, MNS 1-2 стандартын дагуу төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

СХЗГ нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хороодоор хэлэлцэн, дэмжигдсэн стандартын төслийг СХЗГ-ын даргын тушаалаар батлаж, Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг боловсруулахад Европын холбооны “EN 15017, Funeral Services-Requiremenets”, ОХУ-ын “ГОСТ Р 53107-2008, Услуги бытовые, Услуги ритуальные. Термины и определения” ба “ГОСТ Р 54611-2011, Услуги бытовые. Услуги по организации и проведению похорон. Общие требования” стандартуудыг үндэслэл болгосон.

Стандартын төслийг нь холбогдох байгууллагууд буюу сонирхогч талуудаас саналыг авч тусган, зарим заалтын утга агуулгыг найруулж, ойлгомжтой, хэрэглэхэд хүртээмжтэй болгон техникийн хорооны хуралдаан дээр гишүүдийн өгсөн санал, шүүмж зэргийг тусгасан.

Стандартын төслийг “Нийтлэг үйлчилгээний стандартчиллын техникийн хороо” /ТХ-24/-ны 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

СХЗГ-ын Ахлах мэргэжилтэн Н.Батжаргал (Ph.D) Монгол улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006-д нийцүүлэн хянав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46 А

Шуудангийн хаяг: Улаанбаатар хот 210351 Ш/Х-48

Утас: (976-11)263860

Факс: (976-11) 458032

Цахим шуудан: standardinform@masm.gov.mn

Цахим хуудас: www.masm.gov.mn

www.estandard.gov.mn

© СХЗГ, 2020

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.30

Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага	СТАНДАРТЧИЛАЛ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Consumer services. Services in organization and conducting of funerals. General requirements	СТАНДАРТЫН БОЛОВСРУУЛГА MNS 6841 : 2020 ОЛГОСОН ХУВЬ

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн С/21 дүгээр тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршуулгын үйл ажиллагаанд хамаарах үйлчилгээ эрхлэн явуулж буй этгээдийн эрх зүйн хэлбэрээс үл хамаарах байгууллага, аж ахуйн нэгж ба хуулийн этгээд үүсгээгүй хувь хүн, гадаад улсын иргэн, харьяалалгүй этгээд, хэн бүхэнд хамаарна.

Түүх, археологийн малтлага, палентологи, түүхэн дурсгалт газрын судалгаа нь энэхүү стандартад хамаарахгүй.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэсэн. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)–ийг хэрэглэнэ. Үүнд:

MNS 5605, Шарил чандарлах үйлчилгээний байгууллагад тавих ерөнхий шаардлага;

MNS 5606-1, Байгаль орчны хамгаалал. Чандарлах зуух (крематор)-ны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;

EN 15017-2005, Funeral Services – Requirements;

ГОСТ Р 53107-2008, Услуги, бытовые. Услуги ритуальные. Термины и определения;

ГОСТ Р 54611-2011, Услуги, бытовые. Услуги по организации и проведению похорон;

MNS 5377, Цогцосын шинжилгээний арга эмгэг судлалын оношийн бүтэц;

MNS 5530, Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага;

MNS 4968, Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага;

MNS 4990, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага;

MNS 6767, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага;

MNS 4244, Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;

MNS 5390, Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;

MNS 6423, Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага;

MNS 5390, Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;

MNS 4931, Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага;

MNS 5924, Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага;

MNS 5566, Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм.

3 Нэр, томьёо тодорхойлолтууд

Энэхүү стандартад дор дурдсан агуулгад хамаарах нэр томьёо, тодорхойлолтуудыг хэрэглэнэ.

3.1 Талийгаач, түүнд хамаарах ойлголт

3.1.1

талийгаач

сүүлчийн амьсгалаа гаргаж, амьгүй болсон хүнийг хүндэтгэн нэрлэх нэршил

ТАЙЛБАР: Монгол хэлэнд нас барсан хүнийг шилжсэн утгаар өөд болсон, тэнгэрт хальсан, бурхан болооч, талийгч, талийгаач, хүүр, одооч гэх зэргээр хэлдэг. Энэ стандартад "талийгаач" хэмээн бичнэ.

3.1.2

цогцос

талийгаачийн үхлийн шалтгаан тогтоогдоогүй, талийгаачийн бие, эд эрхтэн, түүний хэсэг.

ТАЙЛБАР: үхлийн шалтгаан тогтоогдоогүй, магадлал хийгдээгүй нас барсан хүний бие, эд эрхтнийг хэлнэ.

ТЭМДЭГЛЭЛ: Цогцост үхлийн шалтгааныг тодорхойлох, таниулах, эрэн сурвалжлах, оршуулах арга хэмжээг Монгол улсын нутаг дэвсгэрт мөрдөж буй хууль эрхийн акт, журмын дагуу явуулдаг.

3.1.3

шарил

талийгаач хэн болох нь тогтоогдсон, гэр бүл, төрөл төрөгсөд нь тодорхой бөгөөд үхлийн шалтгаан нь эмнэлгийн байгууллагаар тогтоогдсон, талийгаачийн бие эд эрхтэн, түүний хэсэг.

ТАЙЛБАР: хэн болох нь тогтоогдсон, гэр бүл, төрөл төрөгсөд нь тодорхой боловч үхлийн шалтгаан тогтоогдоогүй, магадлал хийгдээгүй нас барсан хүний бие, эд эрхтнийг хэлнэ.

ТЭМДЭГЛЭЛ: Хэрэв талийгаач ганц бие, хамаатан садан байхгүй эсвэл оршуулах үүргийг хүлээх хүн байхгүй, хамаарал бүхий этгээд оршуулах үүргээс татгалзсан тохиолдолд оршуулах эрх үүргийг холбогдох эрх бүхий этгээдэд хүсэлт гарган шаардаж болно.

3.1.4

чандар

Шарилыг галд хайлуулсны дараа үлдэх нунтаг үнс

3.1.5

Талийгаачийн хүсэл зориг (гэрээслэл)

талийгаач амьд сэрүүн байх үедээ гэрчийг байлцуулан өөрийн нас барсны дараа оршуулгын ажил зохион байгуулах, гүйцэлдүүлэхтэй холбоотой асуудлаар хүсэл зоригийг амаар болон бичгээр илэрхийлсэн захиас.

ТАЙЛБАР: талийгаач амьд сэрүүн байх үедээ хүсэл гэрээслэл эсвэл хүсэл зориг гаргаж байгаагүй тохиолдолд түүний гэр бүл, эсвэл ойр төрлийн хамаатан, эсвэл төлөөлөх байгууллага, эсвэл найз нөхөд, эсвэл амьд ахуй үед нөхөрлөж байсан найз, нөхөд гэсэн шат дараалалд хамаарах этгээд нь хүсэл зоригийг илэрхийлэгч байна.

ТЭМДЭГЛЭЛ: Гэр бүлийн тухай эсвэл бусад холбогдох хууль эрхийн актаар тодотгосон байж болно.

3.1.6

хамаарал бүхий этгээд

талийгаачийн гэр бүл, төрөл садан, угсаа нэгтэй болон ойролцоо амьдарч байсан этгээд, ажиллаж байсан байгууллага.

ТЭМДЭГЛЭЛ: Талийгаачтай гэр бүл, төрөл садан болох ясан болон цусан төрлийн шууд холбоо хамааралтай хүмүүс, үрчилсэн ба үрчлүүлсэн эцэг, эх, ах, эгч, дүү, үр хүүхэд зэргийг хэлдэг.

3.1.7

үйлчлүүлэгч

талийгаачийг оролцуулаад оршуулгад хамаарах үйлчилгээ авч байгаа хамаарал бүхий этгээд.

ТЭМДЭГЛЭЛ: Талийгаачийн хүсэл зоригийг илэрхийлэгч болсон хамаарал бүхий этгээд нь бичгээр, аман хэлбэрээр хийсэн гэрээ, хэлцэлд үйлчлүүлэгч буюу хэрэглэгч тал болно.

3.1.8

оршуулах

талийгаачтай салах ёс гүйцэтгэх, шарил, чандар, эд эрхтнийг хүндэтгэлтэйгээр оршоох ажлыг зохион байгуулах үйл ажиллагаа.

ТАЙЛБАР: Шилжсэн утгаар хойлого, нутаглуулах, хөдөөлүүлэх, хайлах, гаргах, оршоох г.м тухайн газар нутгийн онцлог хэлээр ярьж, бичиж, ойлгож болно. Цаашид "оршуулах/га" хэмээн бичнэ.

ТЭМДЭГЛЭЛ: Оршуулгын ажлын хүрээнд шарил болон чандрыг газрын хэвлийд ба гадарга дээр оршуулдаг/оршоодог.

3.1.9

үйлчилгээ үзүүлэгч

оршуулгад хамаарах үйлчилгээг үзүүлэгч хувь хүн аж ахуйн нэгж, байгууллага.

ТЭМДЭГЛЭЛ: Оршуулгын үйл ажиллагаанд хамаарах төрөл бүрийн үйлчилгээг "үйлчлүүлэгч" талд иргэн аж ахуйн нэгж нь дагнасан төрлөөр салангад, эсвэл цогц үйлчилгээ байдлаар "Оршуулгын мэргэжлийн байгууллага" үзүүлдэг.

ТАЙЛБАР: Этгээд гэдэг нь оршуулгын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй хувь хүн, хуулийн этгээд, ба байгууллагууд байж болно.

ЖИШЭЭ: Төрийн ёслолын алба, цэргийн байгууллага, шашны байгуулага, төрийн бус байгууллага ба хувь хүн.

3.2 Оршуулгын үйлчилгээнд хамаарах ойлголт

3.2.1

Төрийн үйлчилгээ

Монгол Улсын хууль эрх зүйн зохицуулалтын баримт бичиг ба төрийн эрх бүхий байгууллагаас баталсан баримт бичиг дүрэм журам, зааврын дагуу нас барсан хүн, түүний хамаарал бүхий этгээдэд үзүүлэх үйлчилгээ;

3.2.2

оршуулгын ажил үйлчилгээ

Эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, зааврын дагуу талийгаач болон түүний гэр бүлд хүндэтгэл үзүүлэн салах ёс хийж оршуулах/оршоох үйл ажиллагааны цогц нэгдэл

3.2.3

дахин оршуулах

эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр, албан бичиг, хамаарал бүхий этгээдийн санал хүсэлтийн дагуу талийгаачийн шарил, чандарыг гаргах, шилжүүлэн оршуулах/оршоохыг.

3.2.4

оршуулгын мэргэжлийн байгууллага

оршуулгын үйлчилгээг цогцоор хийх чадавх эзэмшсэн, мэргэшсэн албан хаагч, зориулалт бүхий техник технологи, барилга байгууламжтай байгуулага буюу аж ахуйн нэгжийг.

3.2.5

оршуулгын зан үйл

талийгаачийг хүндэтгэн оршуулах, оршуулгын ёслол гүйцэтгэх арга хэмжээний тогтсон ойлголт.

ТАЙЛБАР: шашин шүтлэг, үндэстэн ястны уламжлалт оршуулгын зан үйл байж болдог.

ТЭМДЭГЛЭЛ: Ёслолын үйл ажиллагаан дээр үг хэлэх, хувцас, чимэглэл, ёслолын үйл ажиллагааг тогтсон дарааллын дагуу удирдан явуулах үйл ажиллагааг багтаан ойлгож болно.

3.2.6

оршуулгын газар, байгууламж хариуцсан этгээд

орон нутгийн эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй, оршуулах газрыг төлөвлөлтийн дагуу зохион байгуулж, оршуулгын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн бүрдүүлэлтийг зохих шаардлагад нийцүүлэн тогтмол хөтөлж, хяналт тавьж, хамгаалж, арчлах үүрэгтэй этгээд.

3.2.7

үйлчилгээний хүлээн авах ажилтан

үйлчлүүлэгчтэй анхан шатны харилцаа холбоо тогтоож, мэдээллээр хангах, оршуулгын үйлчилгээний явцыг чиглүүлэх үүрэг бүхий оршуулгын мэргэжлийн байгууллагын ажилтан.

3.2.8

төлөөлөгч

талийгаачтай хамааралтай этгээдээс оршуулгын үйлчилгээтэй холбоотой захиалгыг хүлээн авч зөвлөгөө өгөх, оршуулгын мэргэжлийн байгууллагаас олгосон эрхийн дагуу төлөөлөн ажиллах этгээд

ТЭМДЭГЛЭЛ: Үйлчлүүлэгчийн хүсэлтээр төлөөлөгч нь оршуулгын ёслолын турш дагалдаж, талийгаачийн цогцос эсвэл чандарыг зөөвөрлөх газраас хэрэглэгчийн заасан газар хүртэлх тээвэрлэлтийг хангах, дагалдах үүргийг хүлээж, шаардлагатай тохиолдолд ёслолын удирдагчийн үүргийг гүйцэтгэх чадварыг эзэмшсэн хүн/этгээд байдаг.

3.2.9

ёслол удирдагч

оршуулгын ажлыг зохион байгуулах, хүндэтгэлийн үйл явцыг чиглүүлэх мэргэшсэн хүн

ТЭМДЭГЛЭЛ: Ёслол удирдагчийн үүргийг төлөөлөгч гүйцэтгэж болно.

3.2.10

шарил /цогцос/ хадгалах газар

оршуулахын өмнөх хугацаанд талийгаачийн шарилыг байрлуулах хөргүүр бүхий тусгай тоноглолгдсон байгууламж

ТЭМДЭГЛЭЛ: Нас барсан шалтгааныг нарийн мэргэжлийн анагаах ухааны байгууллагууд буюу эмнэлгийн эмгэг судлалын тасаг, шүүх эмнэлэг гэх мэт газруудад шарил, цогцост үзлэг хийж, тогтоодог.

3.2.11

талийгаачийг тээвэрлэх

хүнийг нас барсан цэгээс оршуулах хүртэлх бүх үйл ажиллагаанд хамаарах хүргэх, шилжүүлэх, зөөвөрлөх үйл ажиллагаа

ТАЙЛБАР: автотээврийн хэрэгсэл, хөсөг тэрэг, чарга, дамнуурга зэрэг төрөл бүрт хамаарах цогцос/шарилыг шийлжүүлэх үйл бүх үйл явцад хамаардаг.

3.2.12

шарилыг оршуулгад бэлтгэх

оршуулгын ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд талийгаачийн шарилыг засаж бэлтгэх, байрлуулах

ТАЙЛБАР: Өнөө үед оршуулгын ёслолд зориулж талийгаачийг биеийн хэлбэрийг засах, нүүрний будалт хийх, үс сахлыг нь угааж засах, хувцас өмсүүлэх, торгоор ороох, ёслолын тавцан дээр бэлтгэх үйл ажиллагаанууд хийгддэг болсон. Зарим тохиолдолд гоц халдварт өвчин, тахлын улмаас нас барсан иргэний шарилыг оршуулгад бэлтгэх үйл ажиллагааг хориглодог.

3.3 Баримт бичигт хамаарах ойлголт

3.3.1

баталгаа

Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээний байгууллагатай үйлчилгээний талаар тохиролцон цаасан дээр үйлдсэн гэрээ, баримт бичиг байна.

ТЭМДЭГЛЭЛ: Талийгаач амьд сэрүүн байхдаа эсвэл нас барсны дараа хамаарал бүхий этгээдийг үйлчлэгч талтай хийж байгаа баримт бичиг баталгаа болно.

3.3.2

үйлчилгээний жагсаалт

хууль тогтоомжийн акт, тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохицуулалтын баримт бичигт заасан төлбөртэй, төлбөргүй үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг.

3.3.3

оршуулах заалт

эрх бүхий байгууллагаас эрүүл ахуй, хүрээлэн буй орчны шаардлагад нийцүүлэх зорилгоор тогтоосон зохицуулалтыг.

ТАЙЛБАР: Иргэн хүний нас барсан шалтгаан, нөхцөл нь хүрээлэн буй орчныг бохирдуулах, халдвар тараах нөхцөл болох тул оршуулгын төрөлд хамаарах далд болон ил тавих г.м заалтыг эрх бүхий байгууллагаас зааж өгсөн байдаг.

3.3.4

эмнэлэгийн маягт

Талийгаачийн нас барсан үхлийн шалтгааныг гэрчлэн баталгаажуулсан тусгайлан тогтсон баримт бичгийг.

ТАЙЛБАР: Нас барсан шалтгаан, оршуулгын төрөлд хориглох заалтыг тодотгосон байж болно.

3.3.5

нас барсны гэрчилгээ

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу нас барсны бүртгэл хөтөлж, олгосон баримт бичгийг.

3.3.6

магадлагаа

талийгаачийг нас барсан, оршуулсан/чандарласан тухай мэдээлэл агуулсан, тээвэрлэлт, хил гаалиар нэвтрүүлэх зэрэгт ашиглах зорилготой баталгаажуулсан баримт бичиг.

3.3.7

зүүлт

шарил /хүүр/, чандрыг тодорхойлох зорилготой овог, нэр, нас, хүйс, нас барсан огноо бүхий тэмдэглэл.

3.3.8

оршуулгын бүртгэл

оршуулгын мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжид хөтөлж буй нас барсан иргэний бүртгэл данс

3.3.9

оршуулгын ёс зүйн хэм хэмжээ

хууль эрхийн зохицуулалтын баримт бичиг болон уламжлалт ёс заншил, зан үйл, дэг жаягаар тогтоосон хэм хэмжээ

3.4 Оршуулгын газарт хамаарах ойлголт

3.4.1**оршуулгын газар**

талийгаачийн шарил, чандрыг оршоох үйл ажиллагааны зориулалттай газар.

3.4.2**оршуулгын цогцолбор**

энэхүү стандартаар тогтоосон шаардлагад бүрэн нийцсэн дэд бүтэц, барилга байгууламж, ерөнхий төлөвлөлт бүхий оршуулгын иж бүрэн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн чадавхтай мэргэшсэн байгууллагын удирдамж дор үйл ажиллагаа явуулах газар нутаг.

3.4.3**хаагдсан оршуулгын газар**

эрх бүхий байгууллагын шийдвэрээр оршуулгын үйл ажиллагаа явуулах буюу оршуулах/оршоохыг хориглосон газар.

3.4.4**зөвшөөрөлгүй оршуулгын газар**

төрийн ба орон нутгийн захиргааны байгууллагад бүртгэгдээгүй, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу олгосон газраас өөр газарт оршоосон газар нутгийг.

3.4.5**орхигдсон оршуулгын газар**

зохих журмын дагуу эзэнгүйд тооцогдсон, удаан хугацааны турш арчилгаа хийгдээгүй байсныг

ТАЙЛБАР: орхигдсон оршуулгын газар нь орчил мөчлөгт орсон газар байж болно.

3.4.6**шилжүүлсэн оршуулга**

зөвшөөрөлтэй оршуулгын газраас бусад газар далд оршуулсан болон ил тавьсан шарилыг шилжүүлэн байршуулсныг

1-Р ТАЙЛБАР: Оршуулгын газарт тодорхой бус, хариуцагч этгээд нэхэмжлээгүй шарил, цогцос, үлдэгдлийг чандарлан шилжүүлж оршоосон буюу булшилсан газрыг.

2-Р ТАЙЛБАР: Хаагдсан, үүсмэл, орхигдсон оршуулгын газрыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжүүлсэн.

3-Р ТАЙЛБАР: Зөвшөөрөлтэй оршуулгын газар байгаа шарилыг талийгаачийн ар гэрийн хүмүүсийн хүсэлтээр шилжүүлэн оршуулсныг.

3.4.7**эрдэсжих**

оршуулсан шарил, цогцос химийн элемент ба энгийн химийн нэгдэл болон задрах үйл явц

ТЭМДЭГЛЭЛ: Эрдэсжилтийн хугацаа нь оршуулгын газар нутгийн байршил, цаг агаарын нөхцөл, хөрс, бүс нутгийн онцлог гэх мэт зүйлсээс хамаардаг.

3.4.8**орчил мөчлөг (эх дэлхийд шингэх)**

газарт оршуулсан шарилд задрал явагдан, газрын хөрсөнд эрдэсжих, газрын гадарга нөхөн төлжиж эдгэх хугацаа

3.5 Оршуулгын байгууламжид хамаарах ойлголт

3.5.1

оршуулгын байгууламж

шарил, чандрыг газар дээр болон газар доор оршоох зорилгоор бүтээсэн байгууламж.

ТЭМДЭГЛЭЛ: Ийм оршуулгын байгууламж нь сүм, суварга, бунхан, дурсгалын хана гэх мэт олон төрөл байдаг.

3.5.2

дурсгалын барилга байгууламж

тухайлсан түүхэн үйл явдал, хүнд зориулсан дурсгалын биет байгууламж бүхий бүтээл

ТЭМДЭГЛЭЛ: Дурсгалын байгууламж нь нийгэмд тухайн ой санамжийг хадгалахад зориулагдсан оршуулгыг хамтатгасан биет байгууламж эсвэл оршуулгын зориулалтгүй хөшөө, дурсгал хэлбэрээр байж болдог.

3.5.3

зан үйлийн танхим

оршуулгын шашны болон хүндэтгэлийн зан үйл явуулах зориулалттай байгууламж

ТАЙЛБАР: Зан үйлийн танхим нь сүм хийд, чандарлах газарт, чандар хадгалах газарт, оршуулгын үйл ажиллагаа явуулж байгаа газарт, шарил хадгалах байгууламж зэрэгт тусгайлан байгуулсан байгууламж болон түр байрших боломжтой хурлын танхим зэрэг байж болдог.

4 Ерөнхий шаардлага

Оршуулгын үйлчилгээ нь нийтийн эрх ашигт нийцэж, хууль эрхийн зохицуулалтын баримт бичиг, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн баримт бичиг, заавар аргачлал ба энэхүү стандарт шаардлагыг гажуудуулахгүйгээр хүмүүнлэг энэрэнгүй ёсны зарчмыг дээдэлж, хүндэтгэлтэй үйлчилгээ үзүүлэхэд чиглэнэ.

4.1 Оршуулгад хамаарах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

4.1.1 Хууль эрхийн зохицуулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.

ТАЙЛБАР: талийгаач, түүний хамаарал бүхий этгээдийн ба үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхахгүй хүмүүнлэг ёсны харилцааг үйлчилгээнд баримтална.

4.1.2 Нийтээр болон тухайн газар нутгийн хүлээн зөвшөөрөгдсөн зан заншилд нийцсэн байна.

4.1.3 Үйлчилгээний жагсаалт нь талийгаачийн хамаарал бүхий этгээд сонголт хийх хувилбарт нөхцлийг багтаасан байна.

4.1.4 Талийгаачийн хүсэл зориг, хамаарал бүхий этгээдийн сэтгэл ханамжид нийцсэн үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлнэ.

4.1.5 Байгаль орчин, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангана.

ТЭМДЭГЛЭЛ: Оршуулгын газар, байгууллага зэрэг нь цэвэрлэх байгууламжтай тохиолдолд хүрээлэн буй орчинд нийлүүлж буй хаягдал бохир ус нь "MNS 4943, Хаягдал ус. Ерөнхий шаардлага" стандартын шаардлагыг хангах, нүхэн жорлонтой тохиолдолд "MNS 5924, Нүхэн жорлон угаадасны нүх. Техникийн шаардлага." зэрэг стандартын шаардлагыг хангасан байхыг эрх бүхий байгууллагаас шаарддаг.

4.1.6 Иргэний бүртгэлийн нэгдсэн тогтолцоо, системтэй уялдана.

4.1.7 Шинжлэх ухаан техник-технологийн ололт амжилтыг нэвтрүүлж, нийцүүлнэ.

4.1.8 Аливаа эрсдэл, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх тогтолцоог хэвшүүлсэн байна.

4.1.9 Оршуулгын үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, шаардлага хангасан болох тухай эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан буюу нотолсон байна.

4.1.10 Оршуулгын үйлчилгээтэй холбоотой асуудлаар хэрэглэгчид мэдээллийг дэлгэрэнгүй танилцуулж, гэрээ байгуулан ажиллана.

4.1.11 Олон улс, бүс нутаг, гадаадын болон үндэсний салбарын нэгдсэн тогтолцоонд нийцтэй байна.

1-Р ТАЙЛБАР: Олон улсын оршуулгын холбооноос гаргасан баримт бичиг, шаардлагад нийцэж байх.

2-Р ТАЙЛБАР: Оршуулгын үйл ажиллагааны чиглэлээр нэгдсэн үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллага ба холбоо, Газрын салбарын кадастрын нэгдсэн системд оршуулгын газрыг бүртгүүлэх г.м.

4.1.12 Харьяалах тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн хэтийн төлөвлөлтөд нийцтэй байна.

4.1.13 Оршуулгад хамаарах үйлчилгээ үзүүлэх байгууламжууд нь Барилгын норм дүрэм ба зохих стандарт шаардлагад нийцсэн байна.

4.1.14 Гамшиг, осол, болзошгүй эрсдлээс сэргийлэх тогтолцоотой байж камерийн хяналтын системтэй байна.

4.1.15 Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд зэрэг салбарын асуудлын хүрээнд гаргасан төрийн захиргааны төв байгууллага буюу холбогдох байгууллагаас гаргасан зөвлөмж, баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

ТАЙЛБАР: Байгалийн гамшиг, халдварт өвчин зэргээс шалтгаалан оршуулгын төрлүүдэд хамаарсан тусгай шаардлага, хөл хорионы дэглэм зэрэг горим тогтоож болдог.

4.1.16 Оршуулгад хамаарх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой барилга байгууламжийн зохион байгуулалт болох орох үүд, ариун цэврийн өрөө зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шийдэл, тоноглолтой байна.

4.2 Оршуулгад хамаарах үйлчилгээний төрлүүдэд тавих шаардлага

Оршуулгад хамаарах биет болон биет бус үйлчилгээг дангаар нь эсвэл хосолсон үйлчилгээний төрөл бүрт тавих шаардлагыг "дагнасан" эсвэл цогц үйлчилгээ үзүүлэх хэлбэр "оршуулгын мэргэжлийн байгууллага" хэлбэрээр төрлүүд болгон ангилах бөгөөд энэхүү стандартын нийтлэг шаардлагыг үндэслэл болгоно.

4.2.1 Оршуулгын үйлчилгээ

4.2.1.1 Гамшиг, онцгой байдлын үед цогцсыг оршуулахад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан зааврыг баримтална.

4.2.1.2 Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Оршуулгын үйлчилгээ эрхлэх төсөл ба тухайн зураг төлөвлөлтийг зөвшөөрсний дагуу Монгол улсад бүртгэлтэй, зөвхөн үндэсний аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааг эрхлэн явуулна.

4.2.1.3 Оршуулгын үйл ажиллагааны төрлүүдэд хамаарах заалтуудын дагуу зөвшөөрөгдсөн оршуулгын газар, нутаг дэвсгэрт үйлдэнэ.

4.2.1.4 Оршуулгын үйл ажиллагаа нь хамаарал бүхий этгээд хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцсэн байна.

ТЭМДЭГЛЭЛ: Оршуулга нь иргэний, цэргийн, төрийн, албаны, шашны зан үйлийн, үндэстний оршуулгын ажил г.м онцлог ялгаатай хэлбэр, төрлүүдтэй байх бөгөөд хамтатгасан хувилбартай байж болдог.

4.2.1.5 Оршуулгын үйлчилгээг оршуулгын мэргэшсэн байгууллага буюу эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн буюу томилогдсон этгээд эрхэлнэ.

ТЭМДЭГЛЭЛ: Оршуулгын ажлыг хувиараа, тусгайлсан албан журмаар гүйцэтгэх этгээд нь оршуулгын мэргэжлийн байгууллагад буюу эрх бүхий байгууллагад энэ тухай мэдэгдэж, бүртгүүлсэн байхыг тухайн орон нутгийн асуудал хариуцсан төрийн байгууллагаас зөвлөдөг.

4.2.1.6 Шарил оршиж/хадгалж байгаа газраас хүлээн авах үе шатаар эхлэж, дурсгалыг хүндэтгэх үйл явцаар үргэлжлэн, оршуулгын зан үйлийг бүрэн гүйцэтгэх үйл явцын дэс дараалал бүхий уялдааг хангасан байна.

4.2.1.7 Оршуулгын төрлүүдэд хамаарах үйлчилгээний баталгаажсан жагсаалттай байх ба үйлчилгээний танхимд хэрэглэгч, хэн бүхэн танилцах боломжтой ил байршуулсан байна.

4.2.1.8 Оршуулгын үйлчилгээг гүйцэтгэхдээ үйлчлүүлэгчийн сонгосон үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

4.2.2 Чандарлах үйлчилгээ /крематори/

4.2.2.1 Талийгаачийн шарилыг чандарлах үйл ажиллагаа нь “MNS 5605, Шарил чандарлах үйлчилгээний байгууллагад тавих ерөнхий шаардлага” стандартад нийцсэн байна.

4.2.2.2 Хүний шарилыг чандарлах зууханд амьтны хүүр чандарлахыг хориглоно.

4.2.2.3 Талийгаачийн шарилтай хамт чандарлаж үл болох эд зүйлсийн жагсаалт, тайлбарыг гаргасан байна.

4.2.2.4 Талийгаачийн хэрэглэж байсан эд зүйлсийг шатаах тохиолдолд зуух нь шарил чандарлах зуухнаас тусдаа зориулалтын байж, холбогдох шаардлагад нийцсэн байна.

4.2.2.5 Гэмт хэргийн шинж чанартай болон эмнэлэгийн бус нөхцөлд нас барсан талийгаачийг чандарлаж оршуулах тохиолдолд эрүүл мэндийн болон прокурорын зөвшөөрлийг үндэслэнэ.

4.2.2.6 Чандарлах заалт бүхий шарил/цогцсонд хамаарах талийгаачийн өвчний онош, оршуулах заавар зэргийг эрүүл мэндийн байгууллагаас баталсан жагсаалтын дагуу хийж гүйцэтгэн, тэдгээрт хамаарах зааврыг баримтална.

4.2.3 Дахин оршуулах үйлчилгээ

4.2.3.1 Дахин оршуулах үйлчилгээг зөвхөн мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

4.2.3.2 Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр цогцыг оршуулсан газраас нь гаргаж шинжилсэн тохиодолд оршуулсан газраас гаргах, дахин оршуулах ажлыг, хамаарал бүхий этгээдийн хүсэлт, захиалгын дагуу гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

4.2.3.3 Эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журмыг баримтлаж, баримт бичгийн бүрдэлт зэргийг нягталж бүртгэнэ.

4.2.3.4 Дахин оршуулах бүртгэл нь шарил буюу цогцыг ухаж гаргах захиалга хүлээн авах, бүртгэх, тээвэрлэх, оршуулах газрыг бэлтгэх, оршуулах ажлыг гүйцэтгэсэн тухай дарааллын дагуу хийх технологийн карттай байх ба энэ тухай дэлгэрэнгүй танилцаж болох архив баримт бичгийн бүрдэл бүхий мэдээллийн нэгдсэн тогтолцоотой байна.

4.2.3.5 Дахин оршуулах үйлчилгээг гүйцэтгэхдээ талийгаачийн хамаарал бүхий этгээдийн сонгосон үйлчилгээг гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэнэ

4.2.4 Оршуулгын газрыг нүүлгэн шилжүүлэх үйлчилгээ

4.2.4.1 Байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр эвдэрч сүйдсэн, дахин төлөвлөлтийг эрх бүхий байгууллагаас шийдвэрлэсэн, хүрээлэн буй орчин, хүний эрүүл ахуйд сөргөөр нөлөөлөх болсон оршуулгын газрыг тухайн орон нутгийн иргэдийн олонхийн саналыг үндэслэн, эрх бүхий төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр нүүлгэн шилжүүлж болно.

4.2.4.2 Хаагдсан оршуулгын газрыг эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас баталсан шийдвэр, товлосон хуваарийн дагуу нүүлгэн шилжүүлнэ.

4.2.4.3 Нүүлгэн шилжүүлэх үйлчилгээг зөвхөн эрх зүйн чадамжтай, мэргэжлийн байгууллагатай хийсэн гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэнэ.

4.2.4.4 Нүүлгэн шилжүүлсэн газар, булшны байршил, дугаар зэргийг оршуулгын мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж нь хөтөлж буй “нас барсан иргэний бүртгэл данс”-д бичиж, тэмдэглэн хадгална.

4.2.5 Төлөөлөгч/Агент/-ийн үйлчилгээ

4.2.5.1 Төлөөлөгч нь оршуулгын үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн байна.

4.2.5.2 Төлөөлөгч нь үйлчлүүлэгчид мэргэжлийн байгууллагын үйлчилгээ, хууль эрх зүйн зохицуулалт, боломж нөхцлийн талаар бодит мэдээллээр хангаж, үйлчилгээний урьдчилсан захиалгыг авч болно.

4.2.5.3 Төлөөлөгч нь оршуулгын үйл ажиллагааг бүхэлд нь удирдан чиглүүлж, зохион байгуулж болох ба үйлчилгээний чанарыг мэргэжлийн байгууллагатай хамтран хариуцна.

4.2.6 Шарил хадгалах үйлчилгээ

4.2.6.1 Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу холбогдох байгууллагаас шарил хадгалах үйлчилгээ, зураг төслийг зөвшилцсөний дагуу Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхлэн явуулна.

4.2.6.2 Цогцос болон шарил хадгалах өрөө, зориулалтын хөргүүр бүхий хөргөгчийг тусдаа байлгана.

4.2.6.3 Цогцос болон шарил хадгалах байгууламж нь эрүүл ахуйн шаардлага хангах зорилгоор гадагшаа халдвар тархаах, дамжуулахаас сэргийлсэн бүтэц, зохион байгуулалттай байна.

4.2.6.4 Шарил хадгалах үйлчилгээг цогцос хадгалах үйлчилгээнээс тусад нь ангилж ялгах бөгөөд үйл ажиллагаа нь уялдаатай байна.

4.2.6.5 Шарил хадгалах үйлчилгээний байгууламж нь хүчин чадлаасаа хамаарч барилгын норм ба дүрэм, стандарт шаардлагад нийцтэй зориулалтын байх бөгөөд үйл ажиллагааны хүчин чадлаас хамаарч гадаад талбайн зохион байгуулалтыг хамтад нь төлөвлөгдсөн зураг төслийн дагуу байх ба дараах шаардлагад нийцсэн байна:

- а) Шарил хадгалах газар нь зориулалтын хөргүүр бүхий хөргөгчтэй байж, цахилгааны нөөц эх үүсгэвэртэй байна.
- б) Шарил хүлээн авах, шарилыг оршуулгад бэлтгэх тусгай өрөө тасалгаа, техник, тоног төхөөрөмжтэй байна.
- в) Шашин, ёс заншил, зан үйлд тохирсон тохижилт бүхий салах ёс гүйцэтгэх, шарилыг үдэн гаргах танхимтай байна.
- г) Авто тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх зам бүхий орц гарц, оршуулгын цувааг зогсоох талбай бүхий зогсоол, явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, хогийн сав, сандал гэх мэт орчны тохижилттой байна.
- д) Харуул хамгаалалттай буюу иж бүрэн камер хяналт, дохиоллын системтэй байна.
- е) Шарил хадгалах газар нь нэгдсэн бүртгэлтэй байх бөгөөд үйлчилгээний чиглэлээр тогтоосон үнэ тарифтай байна.
- ж) Шарил хадгалах газар нь “Барилын норм ба дүрэмд” нийцсэн, батлагдсан зураг төслийн дагуу баригдсан байна.

4.2.6.6 Шарил хадгалах үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж нь эрүүл мэндийн болон шүүхийн шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагааны уялдаатай байна.

4.2.6.7 Үхлийн шалтгаан тогтоогдоогүй цогцос, тусгай маягт бүхий дагалдах бичиг баримтгүй талийгаачийн шарилыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр түр байршуулах, хадгалахыг хориглоно.

4.2.6.8 Шарил хадгалах үйлчилгээ нь шарилыг хүлээн авснаар эхэлж, оршуулгад зориулан байгууламжаас үдэн гаргах хүртэлх үйл явц, хугацаа хамаарна.

4.2.6.9 Шарилыг үдэн гаргахтай холбоотой автотээврийн хэрэгслийг байршуулах, салах ёс гүйцэтгэхэд зориулсан “Санамж”, “Зөвлөмж” зэргийг тараах материал хэлбэрээр бэлтгэн, хэрэглэгч танилцаж болохоор газарт байршуулна.

4.2.6.10 Эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон заалттай харшлахгүй, магадлал хийгдсэн шарилыг хамаарал бүхий этгээдийн хүсэлтээр ар гэр, байгууллагад нь хариуцуулан олгож болно.

4.2.7 Шарилыг оршуулгад бэлтгэх үйлчилгээ

4.2.7.1 Шарилыг оршуулахаас өмнөх хугацаанд мэргэшсэн хүн шарилыг оршуулгад бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэж болно.

ТАЙЛБАР: шарилын угаалга, үс ба гоо засал, хувцас өмсгөх, торгоор ороох, авсанд байршуулах зэрэг үйлчилгээ зэрэгт хамаарах ажилбарууд байж болно.

4.2.7.2 Шарилыг оршуулгад бэлтгэх үйлчилгээг шарил хадгалах газарт, тухайн шарил байгаа газарт, оршуулгын газарт байх зориулалтын тусгай байгууламжид бэлтгэх үйлчилгээг хийнэ.

ТАЙЛБАР: Шарил бэлтгэх үйлчилгээний төрлүүд, тэдгээрт тавих тусгайлсан шаардлага байна.

4.2.7.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангасан орчин байна.

4.2.7.4 Бэлтгэх үйлчилгээг тусгайлан зориулсан багаж, тоног төхөөрөмжийг ашиглан гүйцэтгэх ба зориулалтын дагуу ашиглаж, ариутгах тогтолцоо бүхий заавар журамтай байж, түүнийг мөрдөнө.

4.2.7.5 Үйлчлүүлэгч талтай тохиролцсоны үндсэн дээр шарилыг оршуулгад бэлтгэх заслын үйлчилгээг үзүүлнэ.

4.2.7.6 Эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон хориглосон заалттай, маягтад хориглосон бол, шарилыг оршуулгад бэлтгэх үйлчилгээ хийхийг ямарч тохиолдолд хориглоно.

4.2.8 Ёслолын ажлыг зохион байгуулах үйлчилгээ

4.2.8.1 Талийгаачийг оршуулах ёслолын ажиллагаа нь шашин шүтлэг, үндэсний зан заншил, уламжлалын дагуу хамаарал бүхий этгээдийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн байна.

4.2.8.2 Оршуулгын ёслолын үйл ажиллагаа нь хоорондын уялдаа холбоо бүхий үйл ажиллагааны дараалалтай байна.

4.2.8.3 Талийгаачийг оршуулах зан үйл, онцлог шаардлагаас хамаарч ёслолын үйл ажиллагаа нь хэд хэдэн хэсэгт хуваагдаж болно.

4.2.8.4 Талийгаачийн хамаарал бүхий этгээд нь оршуулгын үйлчилгээ үзүүлэгч этгээдтэй зөвшилцөн зөвхөн нэг этгээдийг Ёслолын удирдагчаар толгойлон удирдахыг зөвшөөрсөн байна.

4.2.8.5 Ёслолын үйл ажиллагаанд хамаарах төрлөөр, хэрэглэгчийг хөтлөх үүргийг ёслолын удирдагч хангана.

4.2.8.6 Ёслолын үйл ажиллагаа, гүйцэтгэх дараалал, дэг жаяг нь үйлчлүүлэгчийн саналыг харгалзан зөвшилцсөн байна.

4.2.8.7 Ёслолын танхимд, оршуулгын газарт хийх ёслолын үйл ажиллагааг оршуулгын чиглэлээр мэргэшсэн хүн хийж гүйцэтгэнэ.

4.2.9 Тээврийн үйлчилгээ

4.2.9.1 Шарил, цогцос тээвэрлэхэд хэрэглэж байгаа дамнуурга ба түүнтэй төстэй төхөөрөмж, сүйх тэрэг, чарга, авто тээвэр, төмөр зам, усан зам, агаарын тээвэр гэх мэт тээвэрлэлтийн үйлчилгээнд эрүүл ахуй, халдваргүйжүүлэлт, аюулгүй байдал, эрсдэлгүй байх шаардлагыг бүрэн хангасан байна.

4.2.9.2 Энэхүү стандартын 4.2.9.1-д заасан төмөр зам, усан зам, агаарын тээврийн үйлчилгээг үзүүлэхдээ тухайн салбарын холбогдох хууль, журмын хүрээнд гүйцэтгэнэ.

4.2.9.3 Авто тээврийн хэрэгслээр шарил тээвэрлэх/зөөвөрлөх үйлчилгээ эрхлэхтэй холбоотойгоор тухайн үйлчилгээг эрхлэх чадамжтай болохоо мэргэжлийн эрх бүхий байгууллагаар нотлуулсан байвал зохино:

а) Тээврийн хэрэгслийн нэмэлт тоноглол болох хөргүүр, тусгай дуут дохио, гэрэл, чимэглэл зэрэг нь эрх бүхий байгууллагаас гаргасан журамд нийцсэн байна.

б) Тээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын үзлэгт тогтоосон хугацаанд орж тэнцсэн.

с) Автотээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, авто зам ашигласаны төлбөр, агаарын бохирдлын төлбөрийг тус тус төлсөн, тээврийн хэрэгслийн болон жолоочийн албан журмын даатгалд хамрагдсан байна.

4.2.9.4 Тээврийн үйлчилгээг захиалагч талын хүсэлтийг харгалзан гэрээгээр гүйцэтгэх ба гэрээнд оршуулгын ёслол эхлэх, дуусах хугацаа, замын зураглал, тээврийн хэрэгслийн хурд зэрэг талуудын хүлээх үүргийг тусгасан байна.

4.2.9.5 Талийгаачийн шарилыг хамаарал бүхий этгээдийн хүсэлтээр энэхүү стандартын 4.2.9.3-ийн б), с)-д заасан шаардлагыг хангасан өөрт хамаарах тээврийн хэрэгслээр тээвэрлүүлж болно.

4.2.9.6 Шарил, цогцосыг тээвэрлэх зай 200 км-ээс дээш тохиолдолд тусгай зориулалтын, хөргүүртэй автотээврийн хэрэгсэл ашиглах бөгөөд зориулалтын битүүмж бүхий тусгай авс, сав баглаа боодлыг ашиглана.

4.2.9.7 Шарил, цогцос тээвэрлэх үйлчилгээнд хүнсний зориулалтын тээврийн хэрэгсэл, хүүхдийн автобус зэргийг ашиглахыг хориглоно.

4.2.9.8 Авто тээврийн хэрэгслээр шарил, цогцсыг тээвэрлэн ёслолын ажлыг зохион байгуулах үйлчилгээ эрхлэхдээ Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, замын хөдөлгөөний дүрмийг баримтлан хөдөлгөөнд оролцоно.

4.2.10 Бусад үйлчилгээнд тавих шаардлага

4.2.10.1 Оршуулгын үйл ажиллагаанд хэрэглэгдэх зарим эд зүйлс болох шарилын хайрцаг, булшны чулуу зэрэг эд зүйлс нь гарал үүслийн баталгаатай байвал зохино.

4.2.10.2 Шашны байгууллага нь иргэн, олон нийтэд оршуулгын үйл ажиллагаа зохион байгуулахтай холбоотой зөвлөгөө өгч зааварлан чиглүүлэх, үйл ажиллагаанд оролцох, буяны зан үйлийг хийхдээ хүмүүнлэг энэрэнгүй хандлагыг эрхэмлэж, төрөөс тогтоосон хууль эрхийн холбогдох актыг дээдэлж, энэхүү стандартаар тогтоосон шаардлагыг хангана.

4.2.10.3 Цогцос/шарилыг хадгалах, тээвэрлэхэд зориулсан, битүүмж бүхий тусгай авс, сав, баглаа боодлыг үйлчилгээнд хэрэглэнэ.

4.3 Оршуулгын газарт тавих шаардлага

4.3.1 Оршуулгын газар нь хил хязгаар тогтоосон шав, тэмдэглэгээтэй, кадастрын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн, гэрчилгээгээр баталгаажсан, хариуцах этгээдтэй байна.

4.3.2 Оршуулгын газрын байршил, талбайн хэмжээ, хил зааг, хамгаалалтын бүсийг тухайн газрын байгалийн онцлог шинжээс хамаарч, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтооно.

4.3.3 Оршуулгын газрын үйл ажиллагааны бүс хязгаарыг шаардлага хангасан хашаа, хаалтаар зааглаж, таних тэмдэг, хаяг, бичвэртэй байна.

4.3.4 Оршуулгын газрын үйл ажиллагааны бүсэд явган хүн, авто тээврийн хэрэгсэл нэвтрэх орц, гарц, тээврийн хэрэгсэлийн нэгдсэн зогсоол, зам, ёслол, зан үйл гүйцэтгэх байгууламж, ариун цэврийн байгууламж, ногоон байгууламж, цогцос оршуулах/оршоох талбай/байгууламж зэргийг тухайн газар нутгийн онцлогт тохируулсан төлөвлөлттэй хийнэ.

4.3.5 Оршуулгын газар хариуцсан этгээд оршуулгын газрын төлөвлөлтөд нийцүүлэн зохион байгуулалтыг эмх цэгцтэйгээр удирдах, зохион байгуулах, зохих баримт бичгийн бүрдүүлэлтийг шаардлагад нийцүүлж тогтмол хөтлөх, хяналт тавих, арчлах үүрэг хүлээнэ.

4.3.6 Оршуулгын газарт оршуулгын цогц үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага байж болох ба хэрэглэгчид шаардлагатай дэд бүтцийг тусгасан байна. А-Мэдээллийн хавсралтыг үзнэ үү.

1-Р ТЭМДЭГЛЭЛ: Оршуулгын цогцолборт орох ба гарах гарц, авто тээврийн зогсоол, далд оршуулгын хэсэг, шарил чандарлах газар, зан үйлийн танхим, бунхан, суварга, ариун цэврийн байгууламж, ногоон цогцолборын шийдэл төлөвлөгөөтэй байна.

2-Р ТЭМДЭГЛЭЛ: Оршуулгын хэд хэдэн ёслолуудыг ээлж дараалан буюу тусдаа зэрэг хийх боломжтой байдаг.

4.3.7 Оршуулгын газрын хөрс, орчныг улирал тутам нэг удаа мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх ба жилд 2 удаа /хавар, намрын улиралд/ шавьж, мэрэгч устгалын ажлыг хийлгэх ба шаардлагатай тохиолдолд тухай бүр нэмэлтээр хийлгэнэ.

4.3.8 Хаагдсан оршуулгын газрыг хариуцах этгээдийг тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагаас томилж нөхөн сэргээлт, арчилгааг хариуцуулж болно.

4.3.9 Оршуулгын газарт байрших булш бүр дугаартай байх бөгөөд түүний байрлал болон холбогдох мэдээллийг бүртгэл, дансанд заавал тусгаж бичсэн байна.

4.4 Оршуулгын байгууламжид тавих шаардлага

4.4.1 Булшны байгууламж

4.4.1.1 Газрын хөрсөнд оршуулах булшны нүх нь дараах шаардлагыг хангана:

- a. Нүхний гүн газрын гадаргаас хэмжсэнээр 1,5 метрээс ихгүй,
- b. Шарил хоорондын зай, булангийн ирмэгээс хэмжсэнээр 2,0 метрээс ихгүй,
- c. Газрын хэвгий налуу бус эгц доош ухагдсан байх,
- d. Хажуугийн булшинд хүндэтгэлтэй хандаж дундын зай бүхий орчныг цэвэр байлгах.

4.4.1.2 Шарилын хөшөөг бэлтгэхэд байгалийн чулуу ашиглах бол чулуу олборлож, ашиглах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаас авсан тухай мэдээллийг талийгаачийн оршуулгын мэдээллийн санд оруулах.

4.4.1.3 Нас барсан хүний тухай дурсамжийг хадгалах зорилготой дурсгалын мэдээлэл агуулсан архитекторын байгууламж, хөшөө, баримал, чулуу зэрэг байж болно.

4.4.1.4 Газрын гадарга дээр байгуулах хөшөө, дурсгалын байгууламжийн овор хэмжээ, зай талбайг тухайн газар нутгийн газар зүйн тогтоц, байгалийн онцлог, зан заншилд тохируулан тодорхой хязгаарлалт хэмжээг орон нутгийн эрх бүхий байгууллагаас тогтоох буюу тогтоосон байж болно.

4.4.1.5 Шарил, чандрыг оршуулгын газарт тусгайлан байгуулсан байгууламж, эсвэл байгальд оршуулах буюу оршоож болно.

1-Р ТЭМДЭГЛЭЛ: Оршуулгын байгууламж нь газар дээр ба газар доорх сүм, суварга, бунхан, ханан байгууламж, хөшөө дурсгалын гэх мэт байгууламж байж болно.

2-Р ТЭМДЭГЛЭЛ: Байгальд оршуулах/оршоох төрлүүд тусгай шаардлагыг хангасан байна.

4.5 Байгууллагад тавих шаардлага

4.5.1 Төрийн байгууллагад тавих шаардлага

4.5.1.1 Монгол Улсын хууль эрх зүйн зохицуулалтын баримт бичиг, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн баримт бичиг, зааврын дагуу нас барсан иргэн, хамаарал бүхий этгээдэд үйлчилгээг шуурхай үзүүлнэ.

4.5.1.2 Салбарын асуудал хариуцсан төрийн эрх бүхий захиргааны байгууллагаас холбогдох жагсаалтын товъёог бүхий багц баримт бичгийг нэгдсэн байдлаар гаргаж, шинэчлэгдсэн тухай бүр холбогдох этгээдэд мэдэгдэж байна.

4.5.1.3 төрийн ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

4.5.2 Оршуулгын мэргэжлийн байгууллага

4.5.2.1 Энэхүү стандартын шаардлагыг бүхэлд нь хэрэгжүүлэх чадамжтай байгууллага байна.

4.5.2.2 Монгол улсын холбогдох хууль, дүрэм, журам, стандартад заасан шаардлагыг хангасан буюу энэхүү стандартын 3.2.4-т заасан шаардлагыг хангасан болохыг баталгаажуулсан байна.

4.5.2.3 Оршуулгын мэргэжлийн байгууллага нь үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий оршуулгын зориулалтын газартай байж А хавсралтад заасан шаардлагыг хангасан байна.

4.5.2.4 Шарил/чандарыг байршуулсан газрын газар зүйн болон холбогдох мэдээллийг эрх бүхий бүртгэлийн байгууллагад мэдээлэх тогтолцоотой байна.

4.5.2.5 Оршуулгын үйлчилгээ эрхлэгч байгууллагад тавих шаардлага, чадавх үнэлгээг В мэдээллийн хавсралтын дагуу, тухайн шаардлагын ач холбогдлоор оноо өгч, тусгай аргачлалын дагуу хяналт, шалгалт, тохирлын үнэлгээг хийнэ.

4.5.3 Хүний нөөцийн хөгжилд тавих шаардлага

4.5.3.1 Оршуулгад хамаарах төрлийн үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, ажилтан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байна.

ТӨГСӨВ.

А хавсралт
(Мэдээллийн)
Оршуулгын мэргэжлийн байгууллагын оршуулгын газар,
байгууламжид тавих шаардлага

№	Үзүүлэлт		Шаардлага
A	1		2
1	Хаяг	Байгууллага нь хаягтай байх	+
		Үйлчилгээний танхим, ажлын байруудыг хаягжуулсан байх, шарил болон чандар байршуулах эгнээ секторыг хаягжуулсан байна.	+
2	Утах үүдний хэсэг болон гадна орчин	Гадна талд байх тээврийн хэрэгслийн орох ба гарах гарцын тэмдэглэгээтэй, зогсоолын тэмдэг бүхий 50-аас багагүй тээврийн хэрэгсэл зогсох хатуу хучилт бүхий талбайтай байна.	+
		Сангийн бойпор байна. (үүдний орчинд нийтэд зориулсан)	+/-
		Хашааны дотор явган хүний зам, талбайтай байх	+
		Үйлчилгээний дараалал, цэг байршлыг харуулсан самбартай байна	+
		Гадна ба дотор талын нийт талбайн гэрэлтүүлэгтэй байх	+
		Гар ариутгах болон зул мандаах өргөөтэй байна.	+
		Ногоон байгууламж төлөвлөлтийн дагуу байна.	+
		Хогийн сав	+
3	Хүлээлгэйн өрөө	Үйлчлүүлэгчдэд зориулсан сандал	+
		Үйлчилүүлэгчид зориулсан тусгай өрөө байж болно	+/-
		Үйлчилүүлэгчидэд зориулсан цэвэр ус, цайны хэсэгтэй байна.	+/-
		Үйлчилгээний холбогдолтой журам, дүрэм, дэг танилцуулга хэлбэрээр байна.	+
		Үйлчилгээний төрөл, тэдгээрийн тариф	+
		Холбооны төхөөрөмжтэй байна (үүрэн телефон, богино долгионы станц)	+
		Үйлчилгээ явуулах зөвшөөрлийн гэрчилгээ	+
		Шашны зан үйлийн танилцуулга материал байна.	+/-
4	Ариун цэврийн өрөө	Ариун цэврийн өрөө нь хүйсээр ялгасан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусдаа өрөөтэй байх ба үйлчилгээний ачаалалтай уялдуулж 20 хүн тутамд 1 суултуур байхаар тооцоолсон байна.	+
		Гар угаалтуур	+
		хатаагч	+
		толь	+
		саван, ариутгалын бодис	+
		хогийн сав(таглаатай, битүү)	+
5	Үйлчилгээний танхим	Шарил байрлуулах тохируулгатай /дээш доош/тавцантай байна	+
		Шарил байршуулах хорготой байна. (Чулуу, шилэн)	
		Өрөөг төрийн ёслол, шашны зан үйлд зохицуулан тохижуулсан байх (доторлогоо, тохируулга бүхий гэрэлтүүлэг, арц хүж уугиулах болон зул өргөх тусгайлсан тавцан г.м)	+
		Үйлчлэгч, үйлчилүүлэгчдийн орох, гарах хаалга тусдаа байх	+
		Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, шаардлагатай бусад хүмүүст зориулсан тэргэнцэр, зам хэрэгслүүд	+
		Талийгаачийн овог нэр гаргах дэлгэц байна.	
		Зохиомол агааржуулалтын системтэй байх (Халуун, хүйтэн тохируулгатай)	+

А хавсралт (үргэлжлэл)

(Мэдээллийн)

Оршуулгын мэргэжлийн байгууллагын оршуулгын газар,
байгууламжид тавих шаардлага

A	1		2
6	Халаалт	Төвлөрсөн	+/-
		Ердийн (өөрийн хэмжээнд халаах чадалтай)	+/-
7	Усан хамгамж	Төвлөрсөн	+/-
		Зөөврийн эсхүл өөрийн гүний худгийн	+/-
8	Агааржуулалт	Ердийн	+/-
		Зохиомол	+/-
9	Гэрэлтүүлэг	Ердийн	+
		Зохиомол	+/-
10	Шал	Хулдаас	+/-
		Чулуун хавтан (Плита)	+/-
		Гантиг	+/-
11	Ажилчдын үйлчилгээ	Хувцасны өрөө	+
		00-ийн өрөө	+
		Угаалгын өрөө	+
		Шүршүүр	+
		Амралтын өрөө	+
		Цайны газар	+
12	Заслын өрөө	Ариутгагч хэрэгсэл эрүүл мэндийн байгууллагаас гаргасан жагсаалтын дагуу (гэрэлтүүлэг, угаалтуур, спирт, гэх мэт)	+
		Өрөөний температур 0-5 градус байна.	+
		Үзлэгийн багаж иж бүрдлээр бүрэн байх	+
		Заслын багаж болон материалууд байна.	+
		Шарил байршуулах хүндэтгэлийн тавцангууд байна.	+
13	Агуулах	Халдвараас сэргийлсэн хувийн хамгаалах хэрэгсэл, хувцасны нөөцтэй тусгай агуулах өрөөтэй байх	+
14	Шашны өрөө	Хүндэтгэлийн бурхантай байна.	+
		Чандар байршуулах ханатай байж болно	+/-
		Ном хурах ширээ сандал бүрэн байна.	+
		Хурал даган баясах үйлчлүүлэгчийн сандалтай байна.	+
15	Шарил тээвэрлэх зориулалтын авто тээврийн хэрэгсэлтэй байж болно		+
16	Шарил түр хадгалах зориулалтын хөргүүртэй/тусгаарлах өрөөтэй байна		+
17	Компьютер иж бүрэн (Шаардлагатай тоогоор)		+
18	Бумба (Шаардагдах нөөцтэйгээр)		+
19	Сац (Шаардагдах нөөцтэйгээр)		+
20	Цөгц (Шаардагдах нөөцтэйгээр)		+
21	Арц, хуж (Шаардагдах нөөцтэйгээр)		+
22	Ороох материал, хувцас (Шаардагдах нөөцтэйгээр)		+
23	Шашны эд зүйлсийн төрөлжсөн дэлгүүр		+/-
Гал унтраах иж бүрдэл	Галын усан хангамж/гидрант		+
	Галын автомат систем/дохиолол, дуут, гэрлэн дохио		+
	Галын сарай /иж бүрдлээр		+
	5кг-ын зөөврийн гал унтраагуур /25м2 тутамд 1 ш байх/		+
	Хяналтын байранд харилцах телефон утас		+
	0,5м3 нөөцтэй элсний хайрцаг, хүрз, хувин		+

ТЭМДЭГЛЭЛ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шийдэлтэй байх.

ТАЙЛБАР: + шаардана, +/- шаардаж болно.

В хавсралт
(Мэдээллийн)

Оршуулгын үйлчилгээ эрхлэгч байгууллагад тавих шаардлага
(хяналт шалгалт, тохирлын үнэлгээ)

№	Асуултууд	Тооцох оноо	Авсан оноо
1	Тухайн газарт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл		
2	"Оршуулгын үйлчилгээ эрхлэх" гэрээг тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээ.		
3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.		
4	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө		
5	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө, түүний дагуу авсан арга хэмжээ		
6	Жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл		
7	Харилцан уялдаатай ажиллах байгууллагатай хийсэн гэрээ		
8	Үйлчилгээнд харилцан уялдаатай ажиллах байгууллага иргэний шаардлага хангасан болох тухай мэдээлэл. Жишээ нь: Шарил зөөвөрлөх болон тээвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэх байгууллага иргэний эрх бүхий байгууллагаас магадлуулсан тухай баримт бичиг.		
9	Иргэдэд үйлчлэх суурин оффис буюу байгууламж		
10	Хаягжилт		
11	Мэргэшсэн хүний нөөцтэй болох тухай диплом, гэрчилгээ, сертификат		
12	Оршуулгын газрын хязгаарыг тогтоосон шав тэмдэг, хашаа		
13	Бүртгэл мэдээллийн цахим ба цаасан мэдээлэл бүхий архивын сан		
14	Оршуулгын үйл ажиллагааг талийгаачийн нас барсныг бүртгэсэн гэрчилгээг үндэслэн зөвшөөрөлтэй газар гүйцэтгэнэ.		
15	Шарил шилжүүлж, чандарласан шарилын талаарх фото зураг, акт, холбогдох баримтыг бүрдүүлж, мэдээллийн сан үүсгэнэ.		
16	Стандарт шаардлагууд		
Оноо тооцох товёолол			
НИЙТ ОНОО			

Тайлбар: Энэхүү хяналт шалгалт, тохирлын үнэлгээний хүснэгт нь ерөнхий мэдээлэл олгох зорилготой бөгөөд эрх бүхий байгууллагаас тогтоосон тусгай үзүүлэлтүүдийг нэмэх буюу хасч, тусгай аргачлалын дагуу шалгалт, үнэлгээ хийж дүгнэлт гаргаж болно.

Ном зүй

- Environmental Protection Agency, 40 CFR part 60, 2011
- Directive 2000/76/EC of the European parliament and of the council of 4 december 2000 on the incineration of waste
- Directive 2010/75/EC of the European parliament and of the Council of 24 November 2010 on industrial emissions (integrated pollution prevention and control) Annex YI
- Environment Agency, Technical Guidelines Note (Monitoring of stack emissions to air, Version 8.1, December 2011)
- Air pollution control law, Emission standards for NOx and Soot and Dust, Emission standards for Toxic Substances, Japan
- Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын Конвенц
- Боломжит арга технологи ба байгаль орчинд ээлтэй практик (БАТ/БЭП) гарын авлага, хог хаягдал шатаах байгууламж
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны А-15 дугаар тушаалаар батлагдсан “Аюултай бохирдуулах бодисын жагсаалт”, “Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын жагсаалт”
- Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах заавар” журам
- Байгаль орчны сайдын 2006 оны 404 дүгээр тушаалаар батлагдсан “Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булах, устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тухай журам”
- Химийн хорт болон аюултай бодис гарын авлага, 2010
- Australasian Cemeteries and Crematoria Association 2004. Cemetery Trust Manual. Victorian Government Department of Human Services, Public Health Division.
- “Review of Emissions from Crematoria in the UK”. AEA Technology Report. Edwards P, 2001.
- “Thailand Dioxin Sampling and Analysis Program. Report by UNEP Chemicals in cooperation with PCD, GTZ, Euro Chlor. Fiedler H, 2001
- “Estimation of PCDDs, PCDFs and PAHs Emission from crematoria in Korea” Kim D. H. et al, 2003
- “Dioxin emissions from French crematoria and associated health impact” Organohalogen Compounds 68; Livolsi B, Labrousse S, Baron P, Fiani E, 2006
- Монголчуудын хойлгын зан үйл. Эрдэм шинжилгээний хурлын материал. Улаанбаатар, 2018
- Монголчуудын хойлгын зан үйл-II. Эрдэм шинжилгээний хоёрдугаар хурлын материал. Улаанбаатар, 2019